



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 03 өдөр

Дугаар 1/579.

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ийн “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Талст чиглэл”ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Ховд аймгийн Хар ус нуурын дэргэд нийтийн ариун цэврийн байгууламж бүхий отоглох, түр буудаллах цэг байгуулах”-н ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Баярсүх -Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд:

Д.Нямтулга - Мэргэжлийн хяналтын газрын
Барилгын техникийн хяналтын Улсын байцаагч

Б.Түмэндэмбэрэл -Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Д.Эрдэнэбат - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
дэд бүтэц хариуцсан гэрээт ажилтан

Л.Батбаяр -Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Б.Мөнхдолгор	-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн
С.Батмөнх	-“Хар ус нуур” орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны дарга
Д.Одончимэг	-Төсөл хэрэгжүүлэгч багийн ажилтан
Б.Бурмаа	-Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
С.Батдорж	-Аймгийн архивын тасгийн дарга
Д.Батсайхан	- “Алтайн сүрлэг цамхаг”ХХК-ний захирал
Т.Мягмардорж	- “Талст чиглэл ”ХХК-ний захирал

Нарийн бичгийн дарга:

Д.Тогтохбаяр

-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. “Талст чиглэл” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган, шалгаж өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх /-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН